

ЗУУРДЫН ХАВЦАЛААС ГЭТЭЛГЭХИЙН ЗАЛБИРАЛ – АЮУЛААС АВРАГЧ БААТАР ХЭМЭЭХ СУДРЫН БҮТЭЦ, АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ

М.Гантуяа (Ph.D)

П.Батбаатар (Магистрант)

Философи, шашин судлалын тэнхим

ШУС. МУИС

Түлхүүр үгс: Цаг хугацааны тухай Буддын сургаал, Банчин эрдэнэ, залбирал ба аврал, сансар ба нирваан, Хоосон чанарын бясалгал, Бардо тойдол, зуурдын төрөл, Реинкарнац, хойд нас, үхэл, төрөл

Товч утга: Энэхүү өгүүлэлд Дөрөвдүгээр дүрийн Банчин эрдэнэ Лувсанчойжижанцаны бичсэн “Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар” хэмээх нэрт сурвалжийг Мэргэний эрхэт Ажаа ёнзин Янжингаавийлодой буюу Лувсандондүвийн тайлбарт тулгуурлан судалж, бүтэц агуулгыг нь тодорхойлох зорилго тавьлаа. Энэхүү сурвалж болон түүний тайлбарын төвд эхийг орчин цагийн монгол хэлэнд өөрийн орчуулсан гар бичмэл эхээр судалгаандаа ашиглав. Уг зохиолд хүний энэ насны амьдралын утга учрыг үхэлтэй холбон хэрхэн тайлбарладаг, үхлийн үед бие, сэтгэлд ямар шинж мэдрэмжүүд бий болдог, энэ насны үйлээр дараа төрөл хэрхэн тодорхойлогддог, бясалгалын ач холбогдол зэрэг асуудлуудыг Буддын уламжлалт сургаал ёсоор авч үзжээ.

* * * * *

Бурханы шашин Монгол оронд дэлгэрээд түүхийн олон үе дамжин бидэнд өвлөгдөн ирсэн. Энэхүү уламжлалт соёлоо судлан оюуны өв сангаа сэргээж, өвөг дээдсийн бичиж үлдээсэн ном судраас сайтар суралцах нь өнөөгийн цаг үеийн бидний нэгэн чухал үүрэг билээ. “Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судар”-ыг судалсанаар цаг хугацааны талаархи Буддын сургаалыг ойлгох, энэ ба хойд нас, амьдралын утга учир, хүний мөн чанарыг ухаарахад дөхөм болох юм. Цаашлаад орчин үеийн шинжлэх ухаан маш хурдацтай хөгжиж байгаа энэ үед бидний оюун мэдлэг улам тэлж боловсорч байгаа ч зөв сэтгэл, зөв төлөвшил, зөв хүмүүжил олох асуудал мэдлэгээс илүү чухал болж тавигдаж байгаа билээ. Тийм учраас сэтгэлээ бурханы номын дагуу хэрхэн зөв шинжлэн бясалгаж, дадуулах асуудлыг судлан тогтоох үүднээс энэхүү судрын учир утгыг сайтар судалж тайлах нь мөн судалгааны ач холбогдолтой болох юм.

“Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судрын” талаар дурдсан ном зохиолууд хэмээвээс:

1. “Суурийн гурван лагшин буюу төрөх үхэх зуурд гуравын тийн агуулага машид тодруулагч зул хэмээгч оршвой”¹.
2. “Амьдрал, үхэл, хойт нас”².
3. “Зургаан зуурд, сансар ба нирваанд хөтлөх нь”³
4. “Бард тойдол буюу үхлийн дараах 49 хоног”⁴.
5. “Бурханч лам Г.Пүрэвбатын ярилцлага, илтгэлийн эмхэтгэл”⁵

Зохиогчийн тухайд

“Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судрыг” зохиогч - Дөрөвдүгээр дүрийн Банчин эрдэнэ Лувсанчойжижанцан нь аравдугаар жарны төмөр морин жил 1570 онд эцэг Цожидцэрэнбалжор, эх Цожал хоёрын хөвгүүн болон мэндэлжээ. 11-р жарны усан барс жил 1662 онд таалал төгссөн. Бага байхад нь Хайдавсанжаа-Иш бээр Бэнса Лувсандондовын хувилгаан дүр хэмээн тодруулсан. 13 сүүдэртэйдээ Бэн хийдэд морилж, Хайдавсанжаа-Ишээс тойн гэгцүлийн санваар хүртсэн ба алдрыг нь Лувсанчойжижанцан хэмээн хайрлав. 14 сүүдэртэйдээ Бэн хийдийн ширээт болов. 17 сүүдэртэйдээ Дашлхүмбэд бэлгэ чанарын сургууль хийхээр өөд болов. 22 сүүдэртэйдээ Дашлхүмбийн 14-р ширээт Дамчой-Яринпэлээс гэлэнгийн сахил хүртсэн. 31 сүүдэртэйдээ Дашлхүмбийн ширээнээ морилсон. 44 сүүдэртэйдээ Ёндонжамц далай ламын ёнзон⁶ болжээ. 47 сүүдэртэйгээсээ эхлэн Сэра, Брайбүн хэмээх хоёр хийдийн хамбаар таван жил суусан. 50 сүүдэртэйдээ Лхасын Төмөр уулын завсард төвд, монголын цэрэг хямран тэмцэлдэхүйд айлдвар болгоолоо зохион амирлуулсан. 52 сүүдэртэйдээ Лувсанжамц далай ламыг тодруулсан. 72 сүүдэртэйгээсээ Шалуу хийдийн хамбаар 20 жил суусан. Манжийн Шунди хаан бээр “Дээр үгүй”⁷ хэмээх цол хайрласны гадна элч илгээж, тамга бэлэг сэлт өргөсөн. Далан таван сүүдэртэйд нь Гүүш хаан Данзанчойжал бээр “Банчэн богд”⁸ хэмээх яруу алдрыг соёрхсон. Түүнээс хойш дараа дараагийн дүрийг Банчэн хэмээх болсон. Түүний зохиол бүтээл нь гарчиг, онол өгүүлэхүй, намтар, зан үйл, маргааны хариу, цааз бичиг тэргүүтэн таван боть буй.

Сударт тайлбар бичсэн хуврагийн тухайд

“Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судрыг” тайлбарлан зохиол бичсэн Мэргэний эрхэт Ажаа ёнзин

¹ Орчуулсан С.Гантөмөр. УБ., 2006 он

² Б.Оюунчимэг. Эрдэм шинжилгээний илтгэл. Илтгэл, өгүүлэл, танилцуулгын эмхэтгэл. №3 МУИС, БССтөв, УБ., 2005 он

³ Гарчин ринбүүчийн тайлбар. Орчуулсан Д. Энхмаа. УБ., 2017 он

⁴ Орчуулсан Т.Мандала. УБ.1998 он

⁵ Бурханч лам Г.Пүрэвбатын ярилцлага, илтгэлийн эмхэтгэл Буцаах эрхгүй бурхадын гэрээслэл Цуврал-1 УБ.2013

⁶ “Ёнзон” гэдэг нь монголоор “огоот баригч” гэсэн үг. Хутагт хувилгаад ихэс дээдэс лам нарын багшийг ийн нэрлэнэ.

⁷ “Дээр үгүй” гэдэг нь “ланамэд” гэсэн төвд үгийн үгчилсэн орчуулга. Дээр нь бус юм үгүй гэсэн утгатай үг.

⁸ “Банчен богд” гэдэг нь монголоор “Сайн оюуны хүчин төгс” гэсэн үг.

Янжингаавинлодой буюу Лувсандондүв нь арван хоёрдугаар жарны төмөр бичин жил буюу нийтийн тооллын 1740 онд Төвдийн “До-на”⁹ хэмээх газар эцэг Лоло хийгээд эх Ваго хоёрын хүү болон мэндэлжээ. Долоон настайдаа лхари Лувсанжунайгаас равжун (тойн) санваарыг хүртэж Лувсандондүв хэмээх алдартай болжээ. Нас сүүдэр арвантавтайдаа “Жа-чун” хийдэд шавьлан сууж их шүнгүүдэд сонсох судлахыг зохиосон байна. Хорин долоон нас сүүдэртэйдээ Төвдийн төв нутагт морилж Брайвун Гоман дацанд шавьлан суужээ. Хорин найман насандаа Банчэн эрдэнэ Балдан-Ишээс гэлэн санваар хүртэв. Гучин хоёр насандаа гавжийн дамжаа барьсан байна. Төвдийн хэл бичгийн дүрэм, одон болон хар зурхай тэргүүтэнд суралцаад их мэргэнд алдаршжээ. Гүнчэн ламын хоёрдугаар дүр Жигмэдвамбу хийгээд Туган гэгээн Чойжи-нямаа тэргүүтэн мэргэдийг шүтэж судар тарнийн олон номуудыг сонссон. Дөчин сүүдэртэйдээ Гүр Намжаллингийн ширээтээр заларсан байна. Энэхүү ламтан бээр зон-нан хийд, манба дацан, дүйнхор дацан зэргийг байгуулж жаран дөрвөн насандаа Жа-чун хийдийн ширээтээр залагдан олон шавь нарт ном эрдмийг түгээж, бурханы шашиныг арвидуулан дэлгэрүүлж байгаад наян найман сүүдэртэйдээ гал гахай жил буюу 1827 онд жанч халжээ.

Судрын бүтэц

“Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судар”¹⁰ нь дараахь асуудлуудыг авч үздэг:

1. Аврал одуулах тухай

Буяны үр дагавар, Нүглийн үр дагавар, Үйлийн үр, энэ ба хойтыг бодох, буруу зүйл хийхгүй болох, Буян хийх сэтгэл төрүүлэх, Буян хийнэ гэдэг нь бусдад туслах өглөг өгөх тэргүүтэн байна.

Чөлөө учралт хүний биеийг олсноо мэдэх нь, Энэ биеийн хэргийг яаж гаргаж шимийг яаж авах вэ? Цаг алдалгүй номонд шамдаж, учир шалтгааныг олж ач холбогдлыг ухаарах.

Үхэх үед аньс тасрахын зовлон, эндүүрлийн үзэгдлүүд, айж эмээх тэргүүтэн гарах тэр үед багшийн увидасыг бясалгах хэрэгтэйг мэдэх.

Таван хүчийг мэдэж түүнийг дадуулсанаар их тусыг олох

Үхэл мөнх бус, Зуурдын талаар цэгцтэй мэдэж авах, үүний үр дүнд ном буянд шамдах хэрэгтэйг мэдэх

2. Үхэх үеийн үйл явц мөн тэр үеийн бие сэтгэлд мэдрэгдэх шинжүүдийн тухай мэдэх

Энэ үйл явцын үед хоосон чанарыг урьд нь маш сайн дадуулсан байх хэрэгтэйг ойлгох, мөн гурван лагшинг хэрхэн урвуулах тухай ойлгох
Зуурдын бие бүтэх үйл явц болон зуурдын төрлийн тухай
Зуурдын ормонд илбийн бие бүтээх

3. Сайн заяаны ялгамжаат бие шүтээнд төрөхөд увидас лугаа барилдуулах гэх мэт сэтгэлийн нарийн увидасуудыг номлосон байдаг.

⁹ “До-на” гэдэг нь монголоор “Нүүр хамар” гэсэн үг

¹⁰ “‘bar do ‘phrang sgrol gyi gsol ‘debs ‘jigs sgrol gyi dpa’ po ches bya ba bzhugs so”.

Бурханы шашинтан дээдсүүд сургаал номлолоо тайлбарлахдаа түүний утгыг багцлан хуваарилсан хэсгүүдэд ангилдаг бөгөөд энэ нь номын утгыг эмх цэгцтэй, эрэмбэ дараалалтайгаар ойлгоход тун хялбар болгодог. Тиймээс Янжингаавилодой ламын тайлбарын¹¹ дагуу энэхүү “Зуурдын хавцалаас гэтэлгэх залбирал - Аюулаас аврагч баатар хэмээгч” судрын хуваарь хэсгүүдийг тодруулбаас:

1. Өөрийн “үлэмжийн тэнгэр”-т тахилыг өгүүлэх Намо Гүрү Манзу гохаяа
2. Залбирлын бодит утга
3. Төгсгөлийн утга хэмээх гурван гол хэсэг болой.

Үүнээс “Залбирлын бодит утга” хэмээх хоёрдугаар бөгөөд гол хэсгийг задалж үзвэл:

- 2.1. Өмнө одуулах нийтийн мөр лугаа найруулсан залбирал
- 2.2. Үхэх үеийн увидас лугаа найруулсан залбирал
- 2.3. Зуурдын увидас лугаа найруулсан залбирал
- 2.4. Төрөл авах увидас лугаа найруулсан залбирал дөрөв болой.

Дээрхи дөрвөн залбирал тус бүр нь хичнээн шүлгийг багтаадаг талаар дурьдахад:

Өмнө одуулах нийтийн мөр лугаа найруулсан залбирал нь “Авралыг одуулж, бодь сэтгэлийг үүсгэж үйлдээд энэ хойд зуурдын аюулаас аврах айлтгалыг өргөх нэгдүгээр шүлэг”, “Чөлөө учрал нь хэрэг ихтэй, олохуйяа бэрхийг санаад шимийг аван чадах адистэд айлтгах хоёрдугаар шүлэг”, “Үхэл мөнх бус тэргүүтнийг дурьдаад орчлонгоос шунал буцаан чадах адистэд айлтгах гутгаар шүлэг” гэсэн гурван шүлгээс бүрдэнэ.

Үхэх үеийн увидас лугаа найруулсан залбиралд эхлээд мөрийг бясалгахын зэтгэрийг арилгаад номын дагуу оюун бодлыг төрүүлэх адистэд айлтгалыг авч үзсэн байх ба энэ нь “Үхэх үед аньс тасрах зовлон үл гарахад адистэд айлтгах дөрөвдүгээр шүлэг”, “Үхэх үеийн хуурамч үзэгдлүүд амирлах адистэд айлтгах тавдугаар шүлэг”, “Үхэх үед багшийн увидасыг санан чадахад адистэд айлтгах зургаадугаар шүлэг”, “Баясал амгалан бадраах хүчтэйгээр санан чадахад адистэд айлтгах долоодугаар шүлэг” гэсэн дөрвөн шүлгээс бүрэлдэнэ.

Үхэх үеийн увидас лугаа найруулсан залбиралд мөн бодьтойгоор үхэх үеийн увидасыг бясалгах ёсонд адистэд айлтгах асуудлыг авч үзэх ба үүнд “Махбодь шингэхийн гадны шинж гарах цагт буяны сэтгэл хүчтэй төрүүлэх наймдугаар шүлэг”, “Дотоодын шинж ургах цагт гүнзгий ахуй ёсыг (хоосон чанар) судлан чадах есдүгээр шүлэг”. “Бүдүүн үзэгдлүүд шингэх үест урьдын буяны

¹¹ “‘bar do ‘phrang sgrol gyi gsol ‘debs ‘jigs sgrol gyi dpa’ po ches bya b`ai agrel ba gdams ngag gsal ba a gsal b`ai sgron me bzhugs so”.

үйлэнд санамсар мэдэмсэрийг хүчтэй төрүүлэх аравдугаар шүлэг”. “Эхний гурван хоосон илт болохын цагт өөрийн сэтгэлийн мөн чанарыг өөрийн туршлагаар мэдрэх арваннэгдүгээр шүлэг”, “Дөрөвдүгээр хоосонгийн үед гэгээн гэрэл эх хүү хоёрыг учруулах арван хоёрдугаар шүлэг”, “Дөрвөн хоосонгийн үед төрөлхийн амгалан лугаа хоосон (чанар)-г учруулсан “ Амгалан-хоосонгийн билгүүнд тэгш агуулахын ” адисыг айлтгах арвангуравдугаар шүлэг” гэсэн 7 шүлгийг оруулдаг байна.

Зуурдын увидас лугаа найруулсан залбирал нь “Зуурдын оронд илбийн лагшинг бүтээхийн тулд адистэд айлтгах арван дөрөвдүгээр шүлэг”. “Эгэлийн зуурд бүтвээс эндүүрлийн үзэгдлийг арилсан тийн цэнгэлд ургуулах адистэд айлтгах арвантавдугаар шүлэг”, “Гадаад дотоод нууцыг урвуулах ёогын хүчээр арилсан оронд төрөхийн адистэд айлтгах арван зургаадугаар шүлэг” гэсэн гурван шүлгээс бүрдэнэ.

Эцсийн төрөл авах увидас лугаа найруулсан залбиралд арван долоодугаар шүлэг багтана.

Судрын агуулга

Мэргэний эрхэт Ажаа ёнзин Янжингаавынлодой Лувсандондүвийн тайлбарт тулгуурлан “Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судрын” агуулгыг тодруулахыг хичээе.

Сударт өгүүлснээр:

(Орчих) гурван цагийн амар ажрагсад, ном, чуулган сэлтэд

Огторгуй сацуу хамаг амьтан, би болон бид бүгдээр

Бодь зүрхний хутагт (хүрэн) хүртэлээ итгэмой

(Бурангуй ертөнцийн) энэ, хойд, зуурдын аюулаас гэтэлгэн соёрх.

Энэхүү шүлгийн утгыг тайлбарлаж: “Бид бүхнийг энэ ба хойд нас, зуурдын ахуй үесийн аюул бүхнээс гэтэлгэхийн тулд итгэл аврал, өмөг садан болж өршөөн соёрх хэмээн өгүүлсэнээр авралдаа багтаан итгэл авралаа зохиов” хэмээчихүй.

Аврал одуулах хэмээх нь, өөрөө орчлон хийгээд муу заяаны зовлонгоос айн эмээх ба түүнээс аврахын хүч чадал чухаг дээдэд буй хэмээн сэтгэл итгэмжлэхийн үүднээс чухаг дээд гуравт оюуны мухраас итгэн даатгахыг хэлдэг аж. Тэрчлэн “аврал одуулах” хэмээх ойлголтын дотор судар, тарнийн анхааран авалт бүхэн багтсан байдаг ба шашинд орохын үүд ч мөний тул маш их чухал зүйл хэмээдэг. Аврал одуулахын утга санааг “Бодь мөрийн зэрэг¹²”-т дэлгэрэнгүй тайлсан буй.

Энэхүү судрын үзэл санааны эх үндэс нь мөнх бусын тухай Буддын онол болой. Энэ талаар сударт:

¹² Богд Зонхава. Бодь мөрийн зэрэг.

Хурагсад хагацаж, хураасан бүхэн барагдах

Өндөрлөгийн эцэс доройтол, төрсний эцэст үхэл

Үхэхээр ч үл барам хэзээ үхэх хувь үгүй

Үе бачимдуу бодлыг үндсэнд төрүүлэн адисла.

хэмээх нь эхийн хэвлийгээс төрж, нэг насаараа энхрийлэн тэтгэсэн энэ бие эцэстээ үхлийн ирмэгт тулж, хуучин ноорхой хувцас мэт хаягдаж, мэдрэл сүнс нь чанад ертөнцөд оддог тухай өгүүлсэн хэрэг ажээ. Хүн үхэхийн цагт жил, сар, өдөр хоногийн чухам аль үест үхэх нь урьдчилан төсөөлшгүй тодорхойгүй байдаг тул үхэл мөнх бусыг оноож мэдэх оюуныг сэтгэлдээ төрүүлэн, үхэл мөнх бусыг бясалгаад орчлонгийн шуналыг няцаахын чухлыг заасан байна.

Богд ламын айлдвар:

Олдоход бэрхийг ухаарвал алмайрч суухын арга үгүй

Онцгой их хэргийг ойлговол хэрэггүй нөхцөөх хайран за

Үхэл мөнх бусыг санавал чанадад одох бэлтгэлээ базаах

Үйлийн үрийг санавал сэрэмжгүй орноос буцъяу л

Тэр мэт тэрхүү дөрвийн үндсийг батжуулваас

Үлдсэн буян ном амар хялбар төрьюу

хэмээсний утга нь: Үхсэний хойно эргэж хүн болж төрөх боломж элбэг бус, зүүний үзүүрт будаа тогтохын адил ховор завшаан байдаг бөгөөд хүн болж төрсөн заяагаа батжуулж, эргэж хүн болох шалтгааныг энэ насандаа бүрдүүлэх хэрэгтэй гэдгийг ухаарвал амьдралын утга учир сая зөв гольдролдоо орно. Буддын дөрвөн үнэний сургаалын утга учир ч үүнд чиглэдэг гэдгийг энд дурьджээ. Мөнх бусын утгыг ухаарснаар бясалгалд шамдан суралцдаг ажгуу.

Сударт өгүүлсэн нь:

Вишай вишайт хоёрыг атхаглан эндүүрэх балгасанд

Бузар дөрвөн махбодиор / бүтсэн /илбийн цогцсоос

Аливаа үхлийн шалтгаанаар мэдрэл сүнс ангижрах үед

Аньс тасрахын зовлонг амирлуулан адислаж хайрла.

хэмээх тэргүүтэн нэгэн шүлгийг зарлиглажээ. Үүний утга хэмээвээс: Вишай орон (объект) хийгээд вишайт оронтын (субъектын) тухай хоёр мэдлэг нь угтаа үнэнд бүтээгүй атал үнэнд бүтсэн мэтээр баримтлах эндүүрсэн атхаг мэдлэг нь аливаа зовлонт буюу зөрчилт сэтгэлийн уг үндэс болох юм. Хүний бие гэдэг бол ариун бус сэтгэлийн үүр уурхай болдог бөгөөд эцгийн дусал, эхийн цус нийлэн алгуур арвижин хурсан гал, ус, шороо, хий дөрвөн махбодийн мөн чанартай, илбэдүүлсэн мэт хуурмаг чанартай гэж үзнэ. Энэхүү цогцод үндэслэх нарийн бүдүүн мэдрэл сүнс нь эдүгээ цагт бие махбодтой хамт нэгэн дор цогцлох боловч эцэстээ гал, ус,

хор, мэс тэргүүтэн гадны шалтгаан хийгээд, өвчин хямрал зэрэг дотоод элдэв зүйлийн шалтгааны эрхээр үхэхийн цагт тус тусдаа салан тусгаарлагдах тул урьдчилан сэтгэлийн зөрчил зовлонгоосоо ангижрахгүй бол үхэх үест сэтгэл нь зөрчил зовлон их байвал дараа төрлийн саад түйтгэр болдог ажгуу.

Хүний амьдралыг цогцлоож буй дүрс, сэрэхүй, хуран мэдэхүй, хуран үйлдэхүй, тийн мэдэхүй гэсэн таван цогцсыг сударт “эндүүрлийн балгас” хэмээн нэрлэсэн байх бөгөөд үүний утга нь: “би” хэмээх нь уг мөн чанараараа үгүй атал “би” хэмээн эндүүрэхийн суурь шалтгаан нь таван цогц болж байдаг тул ийнхүү нэрлэжээ. Мөн зарим сударт “илбийн цогц” хэмээсэн байх нь ч буй. Илбэ лүгээ адил үнэн мэт үзэгдэвч үнэнхүү мөн чанараараа хоосон хийгээд аньс тасрах мэт салан тусгаарлагдах тул тийнхүү нэрлэжээ. Үүнийг эс ойлгосон хүмүүн бээр үхэхийн цагт энэхүү биендээ шунан хоргодож, хагацахаас айн эмзэглэж, зовлонгоо тэсвэрлэхгүй уурлан бухимдаж, энэ насны амьдралдаа хийсэн нүгэлт үйлийнхээ улмаас айж цочих тэргүүтэн эндүүрлийн арилгахад энэхүү судар тустай гэж айлдсан байдаг. Айж эмээх нь сэтгэлийг амарлин тайтгаруулах бясалгалын увидас хүчийг сааруулдаг хор түйтгэр мөн учраас аюух сэтгэлээс хагацах хэрэгтэй хэмээн амарлиулахын соёрхол тавьжээ. Ном буян үйлдэлгүй хилэнц нүгэл хурааж явсан хүмүүний сэтгэл хямран, зүрх нь шимшрэн гэмших ба юу бодож, юу үйлдэх, яах учраа ололгүй арга барагдахын цагт багшийн аман гэгээнээс айлдсан энэхүү судрыг сонсож, анхааран авбаас бясалгалын увидасыг эргэн сануулж, хэрэгжүүлэх боломжтой хэмээчихүй. Хэрвээ урьд өмнө сэтгэлээ амарлиулан дадуулаагүй бол үхэхийн үест анхаарах гэж гүжирлэн зүтгэвч тусыг эс олох тул бясалгалд үргэлж анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үхэхийн цагт айж цочих хийгээд умартах халгах тэргүүтний саад тотгоргүйгээр увидасыг бясалгахад энэхүү судар тустай ажгуу.

Эх болсон хамаг амьтанд зориулж асрахуй, нигүүлсэхүй, бодийн сэтгэлийг дахин дахин бясалган сэтгэлдээ ижилсүүлэн дадуулваас “*дадахын хүч*”-ийг олно. Бясалгалыг энэ болон хойд зуурдын төрөлдөө тасралтгүй анхааран авснаар “*шидэлтийн хүч*”-ийг олно. Чухаг дээдийг өргөн дээдлэх, хүндлэн залбирах, ойртон шадарлах тэргүүтнээр чуулган хураах нь “*цагаан хөрөнгийн хүч*” болдог. Энхрийлэн барих “би” хэмээх үгүй байсаар атал “би” байгаа хэмээн баримталсаны уршигийг бодож энхрийлэн барих үзлээс ангижраад, төрөх, үхэх, зуурдын төрөлд хамаарах бүх юмс дан ганц нэрийтгэлд байгаагаас биш мөн чанараараа эс бүтсэн хэмээн ойлгох нь “*хашираан гаргахын хүч*” ажгуу. Дээдийн номыг анхааран авах лугаа үл хагацах болтугай хэмээн дахин дахин ерөөх нь “*ерөөлийн хүч*” болой. Эдгээр таван хүчийг өдөр бүр анхааран авч, үхэх цагт үүнийгээ ёсчилон дурьдсаар өнгөрвөл “*егүүтгэхийн увьдсанд*” орно.

Айн жихүүцэх, зүрх халширмаар зуурдын гүн хавцлын үхлээс уйсаж цэрвэх биш, харин ч таван хүчний төгөлдөр туршлагынхаа үүднээс төрсөн гэртээ харих мэт сэтгэл баясгалантай, санаа амар төрх байдлыг үүсгэх нь зөв зам ажгуу. Үхлийн ирмэгт тулах үед амсах зовлон нь зовлон бус, орчлонгоос уйдаахуй магад

гарахын сэтгэл хийгээд буяны барилдлагын сануулга мөн хэмээн ухаараад сэтгэлдээ баяслыг төрүүлэн дэлгэрүүлэхийг номложээ.

Үхэхийн цагт буяны сэтгэлийг төрүүлж, ахуй ёс хоосон чанартайг ухаарч, урьдын буяны барилдлагандаа дурьдал мэдэмсэр үүсгэн, хоосон чанар илрэхийн цагт өөрийн сэтгэлийн мөн чанарыг туршлагаараа танин, амгалан хоосны бэлгэ билгийг тэгш агуулан бясалгах тухай сударт номлосон байдаг. Үхлийн ирмэгт тулахад шороо, ус, гал, хий дөрвөн махбодын орнууд аажим аажмаар буурсаар зөвхөн мэдрэлийн (сүнсний) тулгуур шүтээн хийн хүчинд хураагдах ба махбодууд нэгэн нэгэндээ шингэнэ хэмээчихүй.

Тухайлбал, шороон махбод усан махбодод шингэхэд биеийн тамир алдарсаар хөдөлж чадахгүй болж, жингүүдэх мэт байдал мэдрэгддэг учраас “намайг дээш татаарай” хэмээн хэлэх тэргүүтэн илэрдэг. Усан махбод галд шингэхийн цагт хамар ам хатаж шүдэнд өнгөр суух ба уруул ам шантайн эргэж, хамар хөнхийх тэргүүтэн шинж гардаг ажгуу. Гал махбод хийнд шингэхийн цагт нүгэл үйлддэг нэгэн байсан аваас биеийн илч цээжин биенээс эхлэн доошилж зүрхэн тушаа хүртэл хураагдах ба цээжин бие эхлэн хөрнө. Харин буян эдлээч нэгэн мөн аваас илч хөлийн улнаас дээш хураагдах ба эхэлж бөгсөн бие хөрдөг бөгөөд өнгө зүсээ алдана. Салхин махбод сүнсэнд шингэх агшинд амьсгаа давхцан дотогш татахад бэрх, гадагш гаргах нь уртсаж, хорчигнох дуу гаргах тэргүүтэн илэрдэг. Тэр цагт тэдгээр махбодууд нэг нэгэндээ шингэх шинж тэмдгүүдийг ухамсарлан хүлээж авч, асрахуй нигүүлсэхүй бодийн сэтгэл үүсгэн, урьд өмнө дадуулсан буяны барилдлагаа дурьдан санаж сэтгэлээ хүчин төгөлдөр илэрхий болгохыг заажээ.

Сударт өгүүлэх нь:

Ер нь айж цочмоор элдэв зүйлийн эндүү үзэгдлүүд ба

Ялангуяа зэрэглээт, утаат, галт хорхой мэт үзэгдлүүд ургаад

Атхагийн чанарт наян бодлын хийн унаа хаагдахын цагт

Үхэл үгүйн ахуй ёс хоосон чанарыг оноож мэдүүлэн адисла.

хэмээчихүй. Их нүгэл хилэнц үйлдэгч зарим хүний сэтгэлд элдэв зүйлийн муухай дүрс үзэгдэж, муухай дуу сонсогдох тэргүүтэн айж цочмоор олон эндүү үзэгдлүүд мэдрэгддэг ба гэнэт аянга цахилгаан, хутга мэсэнд алагдах, халил ганганд унаж (нисэж) үхэх гэх мэт шинжүүд мэдрэгдэх тохиолдол ч бий. Харин буян үйлдсэн хүмүүсийн сэтгэлд гоё сайхан дүрс, дуу тэргүүтэн элдэв зүйлийн гайхмаар сонин тэмдэгүүд ургадаг байна. Ялангуяа шороо махбод усанд шингэхийн цагт зуны цагт нарны хурц гэрэлд халсан элсний гадаргуу ус мэлтэлзэх мэт цэнхэртэн мяралзаж харагддаг зэрэглээ адил, усан махбод галд шингэхийн цагт нарийн утаа суунаглан цэнхэртэх мэт, гал махбод хийд шингэхийн цагт галт хорхой адил үзэгдлүүд ургадаг ажгуу. Түүний дараа гэгээний мөн чанарт 33 атхаг, түгэхүйн мөн чанарт 40 атхаг, олохуйн мөн чанарт 7 атхаг хийгээд 80 атхаг бодлын хий гүйдэл улам улам сулран суларсаар сүнсэнд шингэх байдлаар хаагдах цагт үхэл гэгч уг мөн

чанараараа хоосон чанартайг онож мэдүүлэн адислагтун хэмээжээ. Үхэл ойртсоны гадаад дотоод шинж тэмдгүүд хэрхэн урьдаас илрэх талаар сударт мөн тодорхой дурджээ.

Гэгээ , түгэхүй, олохуй гурав улирч дараалан шингэж

Сар, нар, харанхуй түгэх адилаан үзэгдэл тодорхойя

Сансар хорвоогийн юмс бүхнийг хоосонд оноохын өгүзэрээр

Сац бас өөрийн сэтгэлийг онож таниулан адисла.

Энэхүү шүлэгт “сүнс гэгээ дор шингэхийн” үест намар цагийн тунгалаг огторгуйд сарны гэрэл түгэх мэт хов хоосрон цагаан замын үзэгдэл сэтгэгдэл ургах ба тэрчлэн “гэгээ түгэхүй дор шингэхийн үест” намар цагийн тунгалаг огторгуйд нарны гэрэл түгэх мэт хов хоосрон улаан замын үзэгдэл, “түгэхүй олохуй дор шингэхийн” үест намрын тунгалаг огторгуйд оройн түнэр харанхуй нөмрөх мэт хар замын үзэгдлүүд аяндаа ургадаг байна. Тэрхүү гурван үзэгдэл ургах боловч үнэн хэрэгтээ орчлон хийгээд нирваанд хамаарах юмс бүхний мөн чанар хоосон гэдгийг өгүзэрийн (йогийн) хүчээр, өөрийн туршлагаар мэдэж онохыг номложээ. Эдгээр мэдрэмжийн нарийн утгыг сударт тайлбарласан буй.

Дээр өгүүлсэн хар замын үзэгдэл баларч, ухаан алдах мэт харанхуйлан дуниартаж, ой санамж алдагдахад “бүхэн хоосон” дор шингээд, эргэж ой санамж сэргэхэд огторгуй өөрийн жинхэнэ өнгө төрхөө илэрхийлнэ. Энэ үест цагаан, улаан, хар зам гурваас ангижирсан намар цагийн үүрийн тунгалаг тэнгэр мэт хов хоосон төрх үзэгдэл ургадаг ажгуу. Тэр нь үхлийн гэгээн гэрэл илэрсэн нь мөн бөгөөд түүнийг “**эхийн гэгээн гэрэл**” хэмээн нэрлэдэг ба мөрийн үест бясалгалын хүчээр төрөх амгалан хоосны билиг билгүүнийг нарийн хоосон чанар буюу “**хүүгийн гэгээн гэрэл**” гэдэг бөлгөө. Тэр хоёр нийлээд эх хүү мэт нүүр золгон учрахад “нэгэн үзүүрт” самади сэтгэл үүснэ. Товчлон өгүүлвээс: Амгалангийн мөн чанарт орсон үхлийн гэгээн гэрэл хоосон чанарт нэгэн үзүүрт сэтгэлээр тэгш агуулах нь эх хүүгийн гэгээн гэрлийг золгуулахын утга болно. Мөн гэгээ, түгэхүй, олохуй гурав гэгээн гэрэл лугаа сэлт дөрвийг дэс дараалан хоосон, машид хоосон, их хоосон, бүхэн хоосон хэмээн нэрлэдэг. Суурийн үесийн гэгээ, түгэхүй, олохуй гурав нь бүдүүн үхэл буюу бодот үхэл мөн бөгөөд улмаар машид нарийн үнэмлэхүй хий сэтгэл илрэх болой.

Бүхэн хоосон гэгээн гэрэл ургахын цагт гялбааны хойноос дагах буюу цахилгаан цахилах адил Эсруагийн гол судсыг дамжин дээш хөтлөхөд түүний илчээр тэргүүний (толгойн, оройн) хүрдэнд (чакра) байрлах туулайтан буюу цагаан бодь сэтгэл (дусал) хайлаад гол судас дүдигийн дундуур доошлон хоолой, зүрх, хүйс, нууцын орны чакра хүртэл дэс дараалан буухад баясал, дээд баясал, ялгамжаат баясал, хамт төрсөн амгалан зэрэг баяслууд төрдөг. Тэр цагт хамт төрсөн амгалан тэрээр хоосон чанарыг онохуй амгалан хоосонг барилдуулахын билгүүнд нэгэн үзүүрт сэтгэлээр тэгш агуулах боломжтой болдог байна. Тэр мэт суурь болон мөрийн гэгээн гэрлийг бодьтой үүсгэн нийлүүлж чадахын тулд энэ насандаа төгсгөхийн зэргэмжийн оноолтыг олох шаардлагатай гэж номложээ.

Сударт өгүүлсэн нь:

Түүнээс сэрэхийн цагт үхлийн гэгээн гэрлийн

Тун нарийн хий сэтгэлээс лагшин найргийн цог бадарсан

Төгс эдлэлт солонгон лагшин зуурдын ормонд бүтэхэд

Тухайлан илбэ адилаын самадийг төгсгөх болгон адисла.

Энэ нь зуурдын сансарын тухай өгүүлж байгаа хэсэг бөгөөд үхлийн гэгээн гэрлийн хий сэтгэл хоёр хийгээр үл мэдэг хөдлөөд амгалан хоосонг барилдуулах тэгш агуулахуй бясалгалаас сэрэхийн цагт үхэхийн үест гэгээн гэрлийн хөлөл болсон таван өнгийн гэрлэн хий үүсч, гэгээн гэрэлт сэтгэл төдийхнөөс бүтсэн нүүр гарын дүртэй, 32 лагшин, 80 найргийн цогийг бадруулан чимсэн тэнгэрийн лагшин нь жирийн хүний зуурдын төрөл бүтэхийн ормонд мөрийн үест дадуулсан эдлэл төгс илбийн биед бүтээд, ариун хийгээд ариун бус илбэ мэт самадийг төгсгөх боломжтой гэж заажээ.

Үүний тулд, илбийн биеийг бодьтой болгон, аглаг сэтгэлийн мухарт үхлийн гэгээн гэрлийг үлгэрийн гэгээн гэрэл болгон урвуулах хэрэгтэй. Илбийн биеийг олон тоон дээр “илбэ мэт самади”, “их амгалангийн самади” гэх мэтээр нэрлэдэг. Энэхүү самади нь бүр шороон махбод усан махбодод шингэх үеээс эхлээд үхлийн гэгээн гэрлийг хүртэл аажмаар дараалан ургадаг. Чингээд гэгээн гэрлээс зуурдын төрөл бүтэхийн цагт гэгээн гэрлээс олохуй, олохуйгаас түгэхүй, түгэхүйгээс сүнсний тулгуур шүтээн бологч шороон махбод хүртэл буцаж төрөх ёс дараалан гардаг байна. Үүнд, үхлийн гэгээн гэрлээс олохуйд босох, гэгээн гэрэл хаагдах, зуурдын төрөл бүтэх гурав нь нэг цагт тохионо. Мөн аглаг сэтгэлийн мухарт үлгэрийн гэгээн гэрэлд оршигч егүзэрээр гэгээн гэрлээс олохуйд босох, илбийн бие бүтэх хоёр нь бас л нэгэн цагт тохиодог ажгуу.

Хэрвээ гэгээн гэрлээс илбийн биеийг бүтээж чадалгүй үйлийн эрхээр зуурдын төрөл бүтвээс тэр даруйд өөрийн ёсоо ажиглана. Хаана төрөх, тэр төрлийнхөө авир байдлыг тогтоох, үйлийн риди хувилгааны хүчээр гурван мянган орныг нэгэн хоромд эргэх, таван эрхтэн тавуул бүрдэх гэх мэт зуурдын шинж тэмдгүүд илэрвэл өөрийгөө зуурдад оршин байгааг ухаарна. Төрөх, үхэх, зуурдын зовлон амсах - эдгээр бүхэн өөрийн минь эндүү үзэгдэл болохоос биш уг утгандаа тэдгээрүүд үнэнд бүтсэн нь хумхын тоосны төдий ч үгүй хэмээн эндүү үзэгдэл бүхнийг арилган, амгалан хоосны үзэгдэлд ургуулахын чухлыг сударт заажээ.

Зуурдыг магадлах зургаан шинж байдаг: 1. эхийн умай, очирт суурин, адистэд шүтээнүүдээс бусад өөр ямарваа нэгэн газар чулуу, тэр ч байтугай уул хаданд үл торох, 2. төрөл садандаа үг өгүүлэвч тэд үл сонсох, үл хариулах, 3. нар, сар, од гурав үл үзэгдэх, 4. алхахын цагт мөр үл гарах, 5. таван эрхтэн бүрдсэн ч солонго адил тунгалаг тул биеийн сүүдэр үл тусах, 6. урьд өмнө зөн билэггүй байсан атал эдүгээ зөн билэгтэй болох – эдгээр нь зуурдад оршиж буйг магадлах зургаан шинж хэмээн номложээ.

Зуурдын ахуй үест шороо махбодын хий урвахад уул нурах мэт дуу, усан махбодын хий урвахад далайн шуурга мэт дуу, гал махбодын хий урвахад хөвч ойд түймэр авалцах мэт дуу, хий махбодын хий урвахад галбын ширүүн салхи хуйлрах мэт – энэ дөрвөн аюумшигт дуу сонсогддог. Мөн там бирд адгуус гурвын үзэгдлүүд, эсвэл мэс агссан эрлэгийн элчийн дүрс, “ал, хяд” хэмээх дуу сонсогдох хийгээд түүнээс улбаалан айж цочих аваас гурван аймшигт үзэгдэл гарах тул савын ертөнц бүхнийг ариун бурханы орон хэмээн сүслэх, шимийн амьтан бүхнийг ядам бурхадын төрхөнд сүслэх, нууц урвахуй дурьдатгал атхагийн гүйлт бүхнийг амгалан хоосны самади хэмээн сүслэснээр гурван егүзэрийн (йогийн) хүчээр ариун бус орчлонд төрөх үүдийг хаагаад дээд орноо төрөх боломжтой болно гэдгийг номложээ.

Судрын төгсгөлд өгүүлсэн нь:

Хүмүүн биеийг олж бурханы шашинтай учирсан энэ мөчид

Хөхөр өвлийн наран мэт ахархан энэ наснаа

Хэрэг өчүүхэн энэ насны үйтгэл бүхнийг огоороод

Хэзээд хэрэгтэй ашдын зүтгэлээ бүтээвэл юутай сайн

“Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх сударт” хүний энэ насандаа хийсэн буянт ба нүгэлт үйл гэж юу болох, тэдгээрийн үр дагавар хэрхэн гарах, энэ ба хойт насны харилцан хамааралыг ухаарах, хүний биеийг олж төрөхийн утга учир, төрсний үр шимийг хэрхэн гаргах, бурханы номоор бясалгал мөрд суралцахын ач холбогдол, үхэх үеийн бие сэтгэлийн үйл явц ба мэдрэмжүүд, тэдгээрийн учир холбогдол, үхлээс айж эмээх сэтгэлийн шалтгаан ба үр дагавар, үхэхийн өмнө сэтгэлдээ үүсгэсэн байвал зохих чадвар дадлууд, үхэл төрлийн мөн чанар, хоосон чанарын гүн утга, зуурдын бие ба сайн заяаны тухай зэрэг асуудлуудыг авч үзсэн байна. Харин Мэргэний эрхэт Ажаа ёнзин Янжингаавилодой буюу Лувсандондүвийн тайлбарт тэдгээр асуудлуудыг дараахь дөрвөн үндсэн асуудалд системчилжээ. Үүнд: 1. Жирийн хүмүүс үхэхээсээ өмнө дараа төрлөө бодож юуг мэдэж, сэтгэлдээ дадуулсан байх тухай, 2. Үхэх үед бие, сэтгэлийн ямар өөрчлөлтүүд гардаг тухай болон тэдгээрээс үүсэх шинэ мэдрэмжүүдийн тухай. 3. Үхсэний дараах зуурдын төрөлд ямар үзэгдэл, үйл явц болдог, тэдгээрийг хэрхэн зохицуулах зааварчилгаа. 4. Шинэ төрөл авах боломжууд ба эерэг, сөрөг үр дүн гарах шалтгаан нөхцлийн тухай эдгээр болно.

Уг зохиолд авч үзэж буй дараа төрөлдөө сэтгэлээ бэлтгэх тухай асуудлуудыг практик амьдралд хэрэгжүүлэхдээ сэтгэлээ төвлөрүүлэх бясалгалыг аажмаар төгөлдөржүүлсээр маш өндөр төвшинд хүргэж чадвал оюуны увидас хүчний дээдэд хүрнэ гэж айлдсан байдаг. Ийнхүү тарнийн номыг гүнзгий судлах үйлийг энэ судар хөтөлдөг байна. Мөн хүн насан өөд болох үеийн зан үйл ба насан өөд бологсдын хойдод зориулсан зан үйлүүдтэй энэхүү зохиол холбогдож байдгаараа оршуулгын зан үйлийн судлалд ч хамаатай юм.

Гэхдээ зохиолын хамгийн гол зорилго нь, буддын сургаалын бүхий л агуулга нь хүний сэтгэлийг тайтгаруулан засахад чиглэдэг гэдгийг харуулж, зовлонгийн үнэн гэдэг нь сэтгэлийн зөрчил хямрал мөн түүнийг бясалгалын хүчээр засч амарлиулан үхэхийн цагт айх эмээх зүйлгүй болж, зуурдын болон дараа төрлийн үйл явцыг ухамсарлан зохицуулах чадварыг сэтгэлдээ дадуулахын чухлыг хүмүүст ойлгуулах явдал юм. Үүгээрээ Буддын сургаалд хүний амьдралын утга учрыг хэрхэн үхэлтэй холбон тайлбарладгийн мөн чанарыг энэ зохиолоор гаргасан байна.

НОМ ЗҮЙ

Эх сурвалж

1. “‘bar do ‘phrang sgrol gyi gsol ‘debs ‘jigs sgrol gyi dpa’ po ches bya ba bzhugs so”.
“Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судар” Цаасны хэмжээ 20х7.2 см, мөрийн тоо 2, хуудас 19, Төвд, Монгол хэлээр бичсэн.
2. “‘bar do ‘phrang sgrol gyi gsol ‘debs ‘jigs sgrol gyi dpa’ po ches bya b`ai agrel ba gdams ngag gsal ba a gsal b`ai sgron me bzhugs so”.
Мэргэний эрхэт Ажаа ёнзин Янжингаавынлодой буюу Лувсандондүв. Зуурдын хавцалаас гэтэлгэхийн залбирал - Аюулаас аврагч баатар хэмээх судрын тайлбар. Цаасны хэмжээ 29х5.5, барын хайрцаг 25х3.5, мөрийн 6, Төвд барын судар.

Бусад ном сурвалж

3. Их бодь мөрийн зэрэг. Орчуулсан Доктор (Ph.D) Т.Булган. УБ. 2004.
4. Суурийн гурван лагшин буюу төрөх үхэх зуурд гуравын тийн агууллага машид тодруулагч зул хэмээгч оршвой. Орчуулсан С.Гантөмөр. УБ., 2006 он.
5. Бурханч лам Г.Пүрэвбатын ярилцлага, илтгэлийн эмхэтгэл Буцаах эрхгүй бурхадын гэрээслэл. Цуврал-1. УБ.2013.
6. Зургаан зуурд, сансар ба нирваанд хөтлөх нь. Гарчин ринбүүчийн тайлбар. Орчуулсан Д.Энхмаа. УБ 2017.
7. Бардо тойдол буюу ихэд сонсгоод тонилгогч хэмээх судар. Орчуулсан Ж.Ерөөлт, М.Тэгшбаяр. УБ. 2015.
8. Бард тойдол буюу үхлийн дараах 49 хоног. Орчуулсан Т.Мандала. УБ.1998.
9. Б.Оюунчимэг. Амьдрал, үхэл, хойт нас. Эрдэм шинжилгээний илтгэл. Илтгэл, өгүүлэл, танилцуулгын эмхтгэл. №3 МУИС, БССтөв, УБ.,2005.
10. Реймонд Муди. Хойт нас. Орчуулсан Р.Чүлтэм. УБ.1993.

ABSTRACT

In this article, purpose of the study is that the study of “bar do ‘phrang sgrol gyi gsol ‘debs ‘jigs sdrol gyi dpa’ po che dya ba bzhugs so” by the Fourth Panchen Lama Lubsangchoijijantsan and its commentary by Ajaa yonzon Yanjingavilodoi or Luvsandondov and to determine structure of the content. My translation of two Tibetan texts into modern Mongolian language has been used in the article. According to traditional Buddhist teachings, the scripture teaches about how human life of this age is related to death, the appearance of physical and mental senses during death, the concept of rebirth and the importance of meditation, etc.